



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/70

Сүхбаатар сум

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж
буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар авах зарим
арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.4, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн "Чанарын болон гүйцэтгэлийн баталгааны тухай" 1/4353 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 онд (Ковид-19) цар тахлын тархалт эрчимжсэн, барилгын бараа материалын үнийн өсөлт, хил гаалийн үйл ажиллагаа тогтворгүй байгаатай холбогдуулан гүйцэтгэгч байгууллагуудад үүссэн санхүүгийн хүндрэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөх, чанарын баталгааг гүйцэтгэлтэй уялдуулан бууруулж гүйцэтгэгчид олгох ажлыг шийдвэрлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга

Я.Мөрөн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд

О.Мөнхбаяр

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Ч.Доржмягмар

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын)

Б.Мөнхбат

("Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ-ын дарга)


Нарийн бичгийн
дарга

Б.Мөнхжаргал

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн)

Беларуская
Арганізацыя
М. Мінск
.....

2.Ажлын хэсгийн шийдвэрт үндэслэн гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөх, чанарын баталгааг гүйцэтгэлтэй уялдуулан бууруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (О.Мөнхбаяр), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Я.Мөрөн) нарт даалгасугай.

The image shows a handwritten signature in cursive script, followed by a rectangular official stamp. The stamp contains some illegible text and a date. To the right of the stamp, the name "Н.ЛХАГВАДОРЖ" is printed in a bold, sans-serif font.

Н.ЛХАГВАДОРЖ

1

